



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг.
Техникийн шаардлага**

MNS 4410 : 2026

Албан хэвлэл

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

**Улаанбаатар хот
2026 он**

ӨМНӨХ ҮГ

Стандартчилал, хэмжил зүйн газар (СХЗГ) нь олон улсын стандартчиллын байгууллагын жинхэнэ гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн ба төрийн бус байгууллагатай хамтран стандартчиллын тогтолцооны бодлогыг хэрэгжүүлдэг.

Тус төв нь үндэсний стандарт боловсруулах ажлыг тухайн салбарын стандартчиллын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд техникийн хороогоор хэлэлцэж 75 %-ийн саналаар дэмжигдсэн стандартын төсөл нь Стандартчиллын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталснаар хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Зам, тээврийн яамны ажилтан
.....
нар шинэчлэн боловсруулсан болно.

Энэхүү стандартыг ТХ15-01/Автозамын техникийн хорооны хурлаар хэлэлцэн зөвшилцөж, Стандартчиллын үндэсний зөвлөлийн тогтоолоор батлуулсан.
СХЗГ-ын ахлах мэргэжилтэн, Монгол Улсын зөвлөх инженер Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2006, MNS 1-2:2006-гийн дагуу хянав.

Энэхүү стандартыг өмнө баталсан MNS 4410 : 2002 “Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг” стандартын оронд мөрдөнө.

Энэ стандартыг Замын хөдөлгөөний тухай Конвенц (Вена, 1968 он)-д бүрэн нийцүүлсэн болно.

Стандарт, хэмжил зүйн газар

Стандарт, хэмжил зүйн газрын 1-р байр
Энхтайваны өргөн чөлөө 46А Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот
Улаанбаатар - 13343, Ш/Х-48
Утас: 266754, 263860
Факс: (976-11)-458032
www.estandart.mn
Email: info@masm.gov.mn

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 43.020

Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг. Техникийн шаардлага	MNS 4410 : 2026
Licence plates for vehicles. Technical requirements	MNS 4410-1: 2002¹, MNS 4410-2:2017-ын оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2026 оны . . . дугаар сарын . . .-ны өдрийн дугаар тогтоолоор батлав.

Энэ стандарт нь 2026 оны . . . дугаар сарын . . . -ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын үзүүлэлт, шаардлагыг заавал мөрдөнө.

1 Хамрах хүрээ

- 1.1 Энэхүү стандарт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтийн хэрэгцээний авто замын хөдөлгөөнд оролцох улсын бүртгэлтэй автотээврийн хэрэгсэл (автомашин, мотоцикл, суррон, трактор, өөрөө явагч машин механизм, чиргүүл)-д олгох бүртгэлийн дугаар болон дугаарын тэмдэгт хамаарна.
- 1.2 Энэхүү стандартаар автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгох улсын бүртгэлийн дугаарын ангилал, бүтэц, дугаарын тэмдгийн төрөл, хэлбэр, хэмжээ, өнгө, хийц, материал, хамгаалалтын элемент болон техникийн шаардлагыг тогтооно.
- 1.3 Энэхүү стандартаар тогтоосон шаардлага нь 2026 оны дугаар сарын-ны өдрөөс хойш шинээр олгох улсын бүртгэлийн дугаар болон дугаарын тэмдэгт хамаарна.
- 1.4 2026 оны дугаар сарын-ны өдрөөс өмнө олгосон улсын бүртгэлийн дугаар болон дугаарын тэмдэгт энэхүү стандартын шаардлагыг дагаж мөрдөхгүй бөгөөд хүчинтэйд тооцно.
- 1.5 Зэвсэгт хүчний болон үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагын байлдааны зориулалттай тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар, дугаарын тэмдэгт энэхүү стандарт хамаарахгүй.

2 Норматив ишлэл

2.1. Энэхүү стандартад дараах норматив баримт бичгийг эш татан хэрэглэсэн болно. Огноотой эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг, огноогүй эшлэлийн хувьд хамгийн сүүлчийн хэвлэл (нэмэлт, өөрчлөлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль;

Монгол Улсын Автотээврийн тухай хууль;

MNS 4410 : 2026

Монгол Улсын Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль;

MNS 4598- Автотээврийн хэрэгсэл. Ангилал. Техникийн ерөнхий шаардлага;

MNS 6269- Замын тэмдэг. Ерөнхий шаардлага;

3.Энэхүү стандартад дараах нэр томъёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1.улсын бүртгэлийн дугаар

эрх бүхий байгууллагаас автотээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгэснийг гэрчлэх зорилгоор олгосон үсэг, цифрийн давхардалгүй хослол

3.2.улсын бүртгэлийн дугаарын тэмдэг

улсын бүртгэлийн дугаарыг стандартын шаардлагын дагуу тэмдэглэн байршуулсан зориулалтын хавтан

3.3.улсын бүртгэлийн дугаарын сан

автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлд ашиглах зориулалттай давхардалгүй дугаарын нэгдсэн бүрдэл

3.4 түр улсын бүртгэлийн дугаар

хязгаарлагдмал хугацаанд ашиглуулах зорилгоор эрх бүхий байгууллагаас олгосон улсын бүртгэлийн дугаар

3.5 улсын бүртгэлийн гэрчилгээ

автотээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгэснийг гэрчлэх албан ёсны баримт бичиг

3.6 дугаарын тэмдгийн ангилал

тээврийн хэрэгслийн зориулалт, ашиглалтын нөхцөлөөс хамааран ялгасан улсын бүртгэлийн дугаарын тэмдгийн төрөл

3.7 цахилгаан тээврийн хэрэгсэл

хөдөлгөөний үндсэн эрчим хүчийг цахилгаан хөдөлгүүр болон цахилгаан эрчим хүч хадгалах системээс авдаг автотээврийн хэрэгсэл

3.8 технологийн зориулалттай тээврийн хэрэгсэл

уул уурхай, хөдөө аж ахуй, барилга, авто зам, эрчим хүч болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагддаг автотээврийн хэрэгсэл, өөрөө явагч машин механизм

3.9 өөрөө явагч машин механизм

өөрийн хөдөлгүүрийн хүчээр хөдөлгөөнд оролцдог, тусгай ажил гүйцэтгэх зориулалттай машин механизм

3.10 паркийн дугаар

байгууллага өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа тээврийн хэрэгсэл, машин механизмд дотоод хэрэгцээнд зориулан олгосон бүртгэлийн дугаар, тэмдэглэгээ

3.11 автомат дугаар таних систем (ANPR)

улсын бүртгэлийн дугаарын тэмдгийг дүрс боловсруулах технологи ашиглан автоматаар таних систем

3.12 оптик тэмдэгт таних технологи (OCR)
дүрс дээрх үсэг, цифрийг таньж цахим өгөгдөл болгон боловсруулах технологи

4 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийн ангилал

4.1 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийг зориулалт, ашиглалтын нөхцөлөөс хамааран дараах ангилалд хуваана.

- а) ердийн тээврийн хэрэгслийн;
- б) төрийн байгууллагын тээврийн хэрэгслийн;
- в) нийтийн тээврийн хэрэгслийн;
- г) цахилгаан тээврийн хэрэгслийн;
- д) технологийн зориулалттай тээврийн хэрэгслийн;
- е) дипломат төлөөлөгчийн газрын тээврийн хэрэгслийн;
- ж) түр улсын бүртгэлийн дугаарын.

4.2 Ердийн тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь иргэн, хуулийн этгээдийн эзэмшлийн автотээврийн хэрэгсэлд олгоно.

4.3 Төрийн байгууллагын тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь төрийн байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаа автотээврийн хэрэгсэлд олгоно.

4.4 Нийтийн тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх зориулалттай автотээврийн хэрэгсэлд олгоно.

4.5 Цахилгаан тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь бүрэн цахилгаан хөдөлгүүртэй болон устөрөгчийн түлшний элементийн цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэлд олгоно.

4.6 Технологийн зориулалттай тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь уул уурхай, хөдөө аж ахуй, барилга, авто зам, эрчим хүч болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагдах автотээврийн хэрэгсэл, өөрөө явагч машин механизмд олгоно.

4.7 Дипломат төлөөлөгчийн газрын тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу дипломат эрх, дархан эрх эдэлдэг байгууллага, албан тушаалтны тээврийн хэрэгсэлд олгоно.

4.8 Түр улсын бүртгэлийн дугаарын тэмдэг

4.8.1 Түр улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь тодорхой хугацаанд ашиглах зориулалттай бөгөөд дараах ангилалтай байна:

- а) импортын тээврийн хэрэгсэл;
- б) экспортын тээврийн хэрэгсэл;
- в) худалдааны зориулалттай тээврийн хэрэгсэл;
- г) аяллын зориулалттай тээврийн хэрэгсэл;
- д) туршилт, судалгааны зориулалттай тээврийн хэрэгсэл.

4.8.2 Импортын тээврийн хэрэгслийн түр улсын бүртгэлийн дугаар нь Монгол Улсад импортоор оруулж ирсэн боловч улсын бүртгэлд бүрэн бүртгүүлээгүй тээврийн хэрэгслийг бүртгэлийн байгууллага, хадгалалтын талбай,

MNS 4410 : 2026

худалдааны төв болон үзлэгийн төв хооронд шилжүүлэн хөдөлгөөнд оролцуулахад хэрэглэнэ.

4.8.3 Экспортын тээврийн хэрэгслийн түр улсын бүртгэлийн дугаар нь Монгол Улсаас экспортлох тээврийн хэрэгслийг улсын хил хүртэл хөдөлгөөнд оролцуулахад хэрэглэнэ.

4.8.4 Худалдааны зориулалттай түр улсын бүртгэлийн дугаар нь худалдах, худалдан борлуулах, үзэсгэлэн, танилцуулга, туршилтын жолоодлого хийх зориулалтаар ашиглагдах бүртгэлгүй тээврийн хэрэгсэлд хэрэглэнэ.

4.8.5 Аяллын зориулалттай түр улсын бүртгэлийн дугаар нь олон улсын гэрээ, хэлэлцээр болон эрх бүхий байгууллагын зөвшөөрлийн дагуу хил дамнан түр хугацаагаар зорчих тээврийн хэрэгсэлд хэрэглэнэ.

4.8.6 Туршилт, судалгааны зориулалттай түр улсын бүртгэлийн дугаар нь үйлдвэрлэгч, импортлогч, судалгааны байгууллагаас техникийн туршилт, баталгаажуулалт, үзүүлэнгийн зориулалтаар ашиглах тээврийн хэрэгсэлд хэрэглэнэ.

4.8.7 Түр улсын бүртгэлийн дугаарын хүчинтэй хугацаа, олгох нөхцөл, ашиглах журмыг автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

5 Ерөнхий шаардлага

5.1 Улсын бүртгэлийн дугаар нь улсын хэмжээнд давхардалгүй байна.

5.2 Нэг улсын бүртгэлийн дугаар нь зөвхөн нэг тээврийн хэрэгсэлд олгогдоно.

5.3 Нэг тээврийн хэрэгсэлд зөвхөн нэг улсын бүртгэлийн дугаар олгоно.

5.4 Улсын бүртгэлийн дугаар нь автотээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаанд хүчинтэй байна.

5.5 Улсын бүртгэлийн дугаарыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөр тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ашиглахыг хориглоно.

5.6 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь тээврийн хэрэгслийн урд болон ар хэсэгт стандартын дагуу бэхлэгдсэн байна.

5.7 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийг бүрэн, тод харагдахуйц байдлаар байрлуулна.

5.8 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийг халхлах, нугалах, тайрах, будах, бүрхэх, гэрэлтүүлгийг өөрчлөх, уншигдах боломжийг бууруулахыг хориглоно.

5.9 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь өдөр, шөнийн нөхцөлд хүний нүд болон автомат таних системээр уншигдах боломжтой байна.

5.10 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь цаг агаарын нөлөөлөл, механик үйлчлэл болон ердийн ашиглалтын нөхцөлд уншигдах чанараа алдахгүй байна.

5.11 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь гэрэл ойлгогч шинж чанартай байна.

5.12 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь хуурамчаар үйлдэх, хуулбарлах, өөрчлөхөөс хамгаалсан хамгаалалтын элементтэй байна.

5.13 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь эрх бүхий байгууллагаас баталсан загвар, хэмжээ, өнгө, бичиглэлтэй байна.

5.14 Арын улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь лацтай байна.

5.15 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь камерын хяналтын болон автомат дугаар таних системийн шаардлагыг хангасан байна.

6 Улсын бүртгэлийн дугаарын бүтэц

6.1 Улсын бүртгэлийн дугаар нь үсэг, цифрийн хослолоос бүрдэнэ.

6.2 Ердийн улсын бүртгэлийн дугаарт дараах үсгийг хэрэглэнэ. А, В, Е, К, М, Н, Р, С, Т, У, Х, Д, Ү

ТАЙЛБАР. Дээрх үсгүүд нь кирилл болон латин бичигт дүрсээрээ ижил танигдах бөгөөд О үсгийг 0 цифртэй андуурагдахаас сэргийлэн хэрэглэхгүй.

6.3 Улсын бүртгэлийн дугаарт 0-9 хүртэлх араб цифрийг хэрэглэнэ.

6.4 Энэ стандартад хэрэглэгдэх Д үсгийг дипломат төлөөлөгчийн газрын тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарт, Ү үсгийг түр улсын бүртгэлийн дугаарт тус тус хэрэглэнэ.

6.5 Автомашины улсын бүртгэлийн дугаар нь 3 үсэг, 4 цифрээс бүрдэнэ.
Жишээ: АВЕ 1234

6.6 Мотоциклийн улсын бүртгэлийн дугаар нь 3 үсэг, 3 цифрээс бүрдэнэ.
Жишээ: АВЕ 123

6.7 Чиргүүл болон өөрөө явагч машин механизмын улсын бүртгэлийн дугаар нь 2 үсэг, 4 цифрээс бүрдэнэ.
Жишээ: АВ 1234

6.8 Автомашины улсын бүртгэлийн дугаарын тоон хэсэг нь 1000-9999 хүртэл байна.

6.9 Мотоциклийн улсын бүртгэлийн дугаарын тоон хэсэг нь 100-999 хүртэл байна.

6.10 Чиргүүл болон өөрөө явагч машин механизмын улсын бүртгэлийн дугаарын тоон хэсэг нь 1000-9999 хүртэл байна.

MNS 4410 : 2026

6.11 Түр улсын бүртгэлийн дугаар нь "ТҮР" гэсэн бичиглэл бүхий болон 5 хүртэл цифрээс бүрдэнэ. Түр дугаарт хүчинтэй огноо бичнэ.
Жишээ: ТҮР 02345

6.12 Түр улсын бүртгэлийн дугаарын 5 хүртэл тоон хэсэг нь 00001-09999 хүртэл дугаарлалт байна.

6.13 Дипломат төлөөлөгчийн газрын тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар нь "ДК" таних тэмдэг болон 4 цифрийн хослолоос бүрдэнэ.
Жишээ: ДК 1234

6.14 Улсын бүртгэлийн дугаар нь улсын хэмжээнд нэгдсэн бүтэцтэй байна.

6.15 Улсын бүртгэлийн дугаар нь аймаг, нийслэл, сум, дүүргээр ялгагдахгүй байна.

7 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийн өнгөний ангилал

7.1 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийн өнгө нь тээврийн хэрэгслийн зориулалт, ашиглалтын нөхцөлөөс хамааран ялгаатай байна.

7.2 Ердийн тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь цагаан дэвсгэр, хар өнгийн бичиглэлтэй байна.

7.3 Төрийн байгууллагын тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь цэнхэр дэвсгэр, цагаан өнгийн бичиглэлтэй байна.

7.4 Нийтийн тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь шар дэвсгэр, хар өнгийн бичиглэлтэй байна.

7.5 Бүрэн цахилгаан хөдөлгүүртэй болон цахилгаан хөдөлгүүрийг үндсэн хөдөлгүүр болгон ашиглаж, дотоод шаталтын хөдөлгүүр нь зөвхөн цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх зориулалттай тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь ногоон дэвсгэр, цагаан өнгийн бичиглэлтэй байна.

ТАЙЛБАР. Хосолмол хөдөлгүүртэй (HEV), залгадаг хосолмол хөдөлгүүртэй (PHEV), шингэрүүлсэн нефтийн хий (LPG), шахсан байгалийн хий (CNG) болон бусад хийн түлшээр ажиллах тээврийн хэрэгсэлд энэ заалт хамаарахгүй.

7.6 Технологийн зориулалт (MNS 4598 стандартад хамаарах)-тай тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь хар дэвсгэр, цагаан өнгийн бичиглэлтэй байна.

7.7 Дипломат төлөөлөгчийн газрын тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь улаан дэвсгэр, цагаан өнгийн бичиглэлтэй байна.

7.8 Түр улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь цагаан дэвсгэртэй байх бөгөөд баруун дээд булангаас зүүн доод булан руу чиглэсэн улаан өнгийн ташуу зурвастай байна.

7.9 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийн өнгө нь өдөр, шөнийн нөхцөлд тод ялгарахуйц байна.

7.10 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийн өнгө нь гэрэл ойлгогч бүрхүүлтэй нийцсэн байна.

8 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийн хэмжээ, хийц

8.1 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийн хэмжээ, хэлбэр нь энэ стандартын А хавсралтад заасан загвар, хэмжээсний дагуу байна.

8.2 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь нарийн болон дөрвөлжин хэлбэртэй байна.

8.3 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь хөнгөн цагаан болон түүнтэй адилтгах бат бөх, зэврэлтэд тэсвэртэй материалаар хийгдсэн байна.

8.4 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь гэрэл ойлгогч бүрхүүлтэй байна.

8.5 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг дээрх үсэг, цифр нь энэ стандартын А хавсралтад заасан загварын дагуу байна.

8.6 Үсэг, цифр нь тод, ойлгомжтой, ялгагдахуйц байна.

8.7 Үсэг, цифрийн хэлбэр нь оптик тэмдэгт таних технологи (OCR) болон автомат дугаар таних систем (ANPR)-ээр танигдах боломжийг хангасан байна.

8.8 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг дээр Монгол Улсыг илэрхийлэх "MGL" таних тэмдэг байрлана.

8.9 "MGL" таних тэмдгийн байршил, хэмжээ нь энэ стандартын А хавсралтад заасан шаардлагад нийцсэн байна.

8.10 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь цаг уурын болон механик үйлчлэлд тэсвэртэй байна.

8.11 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь хэвийн ашиглалтын нөхцөлд уншигдах чанараа алдахгүй байна.

8.12 Арын улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь лацтай байна.

9 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийг байрлуулах шаардлага

9.1 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийг тээврийн хэрэгслийн зориулалтын байрлалд бат бөхөөр бэхэлсэн байна.

9.2 Автомашин нь урд болон ар талдаа тус бүр нэг улсын бүртгэлийн дугаарын тэмдэгтэй байна.

9.3 Суудлын автомашины улсын бүртгэлийн дугаарын тэмдгийг тээврийн хэрэгслийн урд болон ар талын төв хэсэгт байрлуулна.

9.4 Тээврийн хэрэгслийн хийцээс шалтгаалан улсын бүртгэлийн дугаарын тэмдгийг төв хэсэгт байрлуулах боломжгүй тохиолдолд үйлдвэрлэгчээс зориулан гаргасан байрлалд байрлуулж болно.

9.5 Чиргүүл нь ар талдаа нэг улсын бүртгэлийн дугаарын тэмдэгтэй байна.

9.6 Өөрөө явагч машин механизмын улсын бүртгэлийн дугаарын тэмдгийг урд, ард эсхүл үйлдвэрлэгчээс зориулан гаргасан бүрэн харагдахуйц байрлалд байрлуулна.

9.7 Мотоцикл нь ар талдаа нэг улсын бүртгэлийн дугаарын тэмдэгтэй байна.

9.8 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь хөдөлгөөнд оролцох үед бүрэн харагдахуйц байна.

9.9 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь зориулалтын бэхэлгээнд хөдөлгөөнгүй, бат бөхөөр тогтоогдсон байна.

9.10 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийг тонгойлгох, нугалах, эргүүлэх, хазайлгах, сунгаж илүү гаргах, эвхэх болон уншигдах боломжийг бууруулах байдлаар байрлуулахыг хориглоно.

9.11 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн халхлах, бүтээх, бүрхэх, хаахыг хориглоно.

9.12 Ачаа, нөөц дугуй, шат, дугуй тээвэрлэгч, чирэх төхөөрөмж болон бусад тоноглол нь улсын бүртгэлийн дугаарын тэмдгийг халхалж болохгүй.

9.13 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг халхлагдах нөхцөл үүссэн тохиолдолд арын улсын бүртгэлийн дугаарын тэмдгийг нэмэлтээр тээврийн хэрэгслийн арын дээд хэсэгт бүрэн харагдахуйц байрлуулна.

9.14 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийн байршил, бэхэлгээ нь энэ стандартын А хавсралтад заасан шаардлагад нийцсэн байна.

9.15 Түр улсын бүртгэлийн дугаарыг автотээврийн хэрэгслийн урд болон хойд хэсэгт байрлуулах зориулалттай, хэвлэмэл хатуу хавтан материалаар үйлдвэрлэх бөгөөд товойлгон хэлбэржүүлэхгүй.

9.16 Хийцийн хувьд тэмдэг байрлуулах зориулалтын хэсэггүй тээврийн хэрэгслийн тэмдгийг тээврийн хэрэгслийн өргөний дагуу аль болох төвд байрлуулах бөгөөд боломжгүй тохиолдолд хөдөлгөөний чигийн дагуу зүүн гар талд байрлуулна. Тэмдгийг тээврийн хэрэгслийн уртын тэнхлэгт перпендикуляр, босоо байрлуулах бөгөөд дээд ирмэг нь газрын гадаргуугаас 1200 мм-ээс ихгүй, доод ирмэг нь 300 мм-ээс багагүй өндөрт байна.

10 Хамгаалалтын шаардлага

10.1 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь хуурамчаар үйлдэх, хуулбарлах, өөрчлөхөөс хамгаалсан хийцтэй байна.

10.2 Арын улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь зөвшөөрөлгүйгээр салгах, шилжүүлэх, өөрчлөхөөс сэргийлсэн лацтай байна.

10.3 Лац нь нэг удаагийн хэрэглээтэй байх бөгөөд эвдэрсэн, гэмтсэн тохиолдолд дахин ашиглах боломжгүй байна.

10.4 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг нь гэрэл ойлгогч бүрхүүлтэй байна.

10.5 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг дээрх үсэг, цифр, өнгө, дүрс болон бусад тэмдэглэгээг өөрчлөхийг хориглоно.

10.6 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг дээр автомат дугаар таних систем (ANPR), оптик тэмдэгт таних технологи (OCR), камерын хяналтын системийн уншилт, танилтад саад учруулах зориулалттай наалт, бүрхүүл, хальс, будаг, шүршигч бодис болон бусад материалыг хэрэглэхийг хориглоно.

10.7 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийн өнгө, гэрэл ойлголт, уншигдах байдалд нөлөөлөх аливаа өөрчлөлт хийхийг хориглоно.

10.8 Лацны загвар, техникийн үзүүлэлт нь энэ стандартын А хавсралтад заасан шаардлагад нийцсэн байна.

10.9 Түр дугаарын тэмдгээс бусад бүртгэлийн дугаарын тэмдгийн баталгаат хугацаа нь үйлдвэрлэсэн өдрөөс хойш 3 жилээс багагүй байна.

11 Туршилтын арга

11.1 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийн хэмжээ, хэлбэрийг хэмжилтийн багажаар шалгана.

11.2 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийн хийц, тэмдэглэгээ, бичиглэлийн байршил, бэхэлгээ, байрлал, арын улсын бүртгэлийн дугаарын тэмдэгт байрлуулсан лацны бүрэн бүтэн байдал нь энэ стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг техникийн хяналтын үзлэг болон эрх бүхий байгууллагын хяналт шалгалтын явцад шалгана.

11.3 Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг дээрх үсэг, цифрийн уншигдах байдлыг нүдээр болон автомат дугаар таних системээр шалгана.

11.4 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийн өнгө нь энэ стандартын Б хавсралтад заасан өнгөний кодтой нийцэж байгаа эсэхийг үзлэгээр болон шаардлагатай тохиолдолд баталгаажсан хэмжих хэрэгслээр шалгана.

11.5 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийн гэрэл ойлгогч шинж чанарыг баталгаажсан хэмжих хэрэгслээр шалгана.

ДУГААРЫН ЗАГВАР, ХЭМЖЭЭ


А.1.1 Улсын бүртгэлийн дугаарын тэмдгийн хэмжээ, бичиглэл, хүрээ, хамгаалалтын тэмдэглэгээ нь энэ хавсралтын зурагт нийцсэн байна.

А.1.2 Бүх хэмжээг миллиметрээр (мм) илэрхийлнэ.


А.1.3 Зурагт үзүүлсэн үсэг, цифр нь жишээ бөгөөд дугаарын бүтэц нь стандартын 6 дугаар бүлэгт нийцсэн байна.

А.1.4 Бичиглэл нь OCR автомат таних системд нийцсэн байна.


1. Энгийн нарийн дугаар




2. Энгийн дөрвөлжин дугаар




3. Дипломат дугаар




4. Механизм дугаар




5. Чиргүүл дөрвөлжин дугаар



6. Мотоцикл дугаар











7. Лац











8. ЗИП код





















Хавсралт Б

ӨНГӨНИЙ КОД

№	Тээврийн хэрэгслийн ангилал	Дэвсгэр өнгө	Бичиглэлийн өнгө	Нэмэлт тэмдэглэгээ
1	Ердийн	Цагаан	Хар	—
2	Төрийн байгууллагын	Цэнхэр	Цагаан	—
3	Нийтийн тээвэр	Шар	Хар	—
4	Цахилгаан (бүрэн, REEV/EREV)	Ногоон	Цагаан	—
5	Дипломат байгууллагын	Улаан	Цагаан	—
6	Цэргийн болон Технологийн зориулалттай	Хар	Цагаан	—
7	Түр улсын бүртгэлийн дугаар	Цагаан	Хар	Улаан ташуу зураас

Өнгө	RAL Classic	CMYK	RGB	HEX
Цагаан	RAL 9016	0, 0, 0, 0	242, 243, 244	#F2F3F4
Хар	RAL 9005	0, 0, 0, 100	10, 10, 10	#0A0A0A
Цэнхэр	RAL 5005	100, 39, 0, 35	0, 83, 135	#005387
Шар	RAL 1023	0, 20, 100, 0	255, 199, 44	#FFC72C
Ногоон	RAL 6024	100, 0, 72, 20	0, 154, 68	#009A44
Улаан	RAL 3020	0, 100, 100, 10	204, 6, 5	#CC0605

ГЭРЭЛ ОЙЛГОЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Цагаан	Шар	Улаан	Цэнхэр	Ногоон	Хар
Гэрэл ойлголтын коэффициент RA (кд·лк ⁻¹ ·м ⁻²), хамгийн бага	≥100	≥70	≥20	≥15	≥20	-

ТӨГСӨВ.